

## “НИЙГЭМ СУДЛАЛ” ХИЧЭЭЛИЙН ДЭВШИХ

### ШАЛГАЛТЫН ДААЛГАВАР

Анги:10

Хугацаа: 80 минут

Нийт оноо: 100

оноо

Сурагчийн нэр:

Нэгдүгээр хэсэг 30 даалгавар 60

40 оноо

Хоёрдугаар хэсэг 4 даалгавар

1. “Нийгмийн бүтэц гэдэг нь нийгмийн хэсэг, элементүүдийн хооронд бэхжсэн тогтвортой харилцаа холбоо” гэж үзсэн социологич хэн бэ? (2 оноо)  
a. О.Конт      b. Ж.Г.Мид      c. В.Занден      d. К.Маркс      e. М.Вебер
2. Аль нь тоон судалгааны арга вэ? (2 оноо)  
a. Мэдээллийн утгыг ойлгох, дүрслэн харуулхаар зорино  
b. Мэдээлэл нь баримт бичиг, ажиглагдсан зан үйл, уг яриа байна  
c. Хэмжилтийг мэдээлэл цуглуулхаас өмнө хийж, авах мэдээллээ стандартчилна.  
d. Задгай мэдээллээс ерөнхий сэдэв, түүний нотолгоог олж авахад дүн шинжилгээ чиглэнэ
3. Ямар улсын санаачлагаар Монголд хандивлагч улсуудын зөвлөлгөөн анх зохион байгуулагдсан бэ? (2 оноо)  
A. Герман      B. Япон      C. БНСУ      D. АНУ      E. Монгол
4. Аль нь нийгэмшлийн хүчин зүйлүүдэд шууд хамарагдахгүй вэ? (1 оноо)  
A. Боловсролын түвшин      B. Хэлний мэдлэг      C. Гэр бүлийн орчин  
D. Хамт олны хүрээлэл      E. Нутаг дэвсгэрийн хэмжээ
5. “Соёл нь хүн нийгмийн гишүүн болохынхoo хувьд эзэмшдэг мэдлэг, итгэл үнэмшил, урлаг ёс суртахуун, хууль, зан заншил болон бусад чадвар, дадлуудыг багтаасан цогц бүхэл юм” гэж дараах эрдэмтдээс хэн нь үзсэн бэ? (2 оноо)  
a. Р.Бенедикт      b. Э.Тайлор      c. Ж.Мёрдок      d. А.Гидденс      e. Э.Кассирер
6. Аливаа зүйлийн үнэн эсэхийг шалган тодорхойлох, туслах арга, аргачлал, зарчимд тулгуурладаг нь мэдлэгийн аль төрөл вэ? (2 оноо)  
a. Шашин      b. домог      c. философи      d. шинжлэх ухаан      e. Урлаг
7. Соёлыг бүрдүүлэгч элементүүдийг тоочихдоо илүүц зүйл дурдсан бол аль нь вэ? (2 оноо)  
a. Бэлгэ тэмдэг      b. Хэл      c. Мэдлэг      d. Нийгэмшилт      e. Үнэлэмж
8. Нийт хүн төрөлхтний хувьд хүлээн зөвшөөрөгддөг утгат чанарууд бөгөөд сайн үйл, эрх чөлөө, шударга ёсыг ямар ч ард түмэн эрхэмлэдэг. Энэ нь: (2 оноо)  
a. Үнэлэмж      b. Үнэлэмжийн баримжаа      c. Үнэлгээ      d. Үнэт зүйл . Тохирох хариулт алга
9. Нийгмийн туршлагыг хуримтлуулж, цааш дамжуулж байдаг нь соёлын ямар үүрэгт хамаарах вэ? (2 оноо)  
A. Харилцааны үүрэг

- В. Хэм хэмжээ тогтоох үүрэг  
 С. Танин мэдүүлэх үүрэг  
 Д. Мэдээллийн үүрэг  
 Е. Албан ёсны үүрэг
10. "Хүний үндсэн эрх, хувь хүний нэр төрд итгэх итгэлийг дахин батлах..." гэсэн зорилготой НҮБ хэдэн онд байгуулагдасан бэ? \2 оноо\
- |            |            |            |            |            |
|------------|------------|------------|------------|------------|
| a. 1924 он | b. 1940 он | c. 1945 он | d. 1948 он | e. 1992 он |
|------------|------------|------------|------------|------------|
11. Тодорхой ажиллагааг эхлүүлэх, эсвэл дуусгавар болгох тухай захиргааны байгууллагад гаргасан хүсэлтийг..... гэнэ. \2 оноо\
- |             |           |              |            |           |
|-------------|-----------|--------------|------------|-----------|
| a. Мэдэгдэл | b. Гомдол | c. Нэхэмжлэл | d. Өргөдөл | e. Баримт |
|-------------|-----------|--------------|------------|-----------|
12. Иргэн хүн захиргааны байгууллагатай харилцах үндсэн хэлбэрийг тоочихдоо илүүц зүйл оруулсан бол аль нь вэ? \2 оноо\
- |                  |                   |                                   |                         |
|------------------|-------------------|-----------------------------------|-------------------------|
| a. гомдол гаргах | b. өргөдөл гаргах | c. нотлох баримт гаргах шалгуулах | d. санал, хүсэлт гаргах |
|------------------|-------------------|-----------------------------------|-------------------------|
13. Эрх зүйн бүрэн бус чадамжтай хүн гэж хэнийг хэлэх вэ? \2 оноо\
- |                               |                              |
|-------------------------------|------------------------------|
| a. 14-18 хүртэлх насын хүүхэд | b. 18- аас дээш насын хүмүүс |
| c. 7-14 хүртэлх насын хүүхэд  | d. 7 хүртэлх насын хүүхэд    |
| насын хүүхэд                  | e. 16 хүртэлх                |
14. Тэтгэврийн даатгалын сангаас даатгуулагчид олгох тэтгэврийн төрелд аль нь хамаарахгүй вэ? \2 оноо\
- |                         |                               |               |
|-------------------------|-------------------------------|---------------|
| a. Өндөр насын тэтгэвэр | b. Тахир дутуугийн тэтгэвэр   | c. Оршуулгын  |
| тэтгэм                  | d. Тэжээгчээ алдсаны тэтгэвэр | e. Дээрх бүгд |
| хамаарна                |                               |               |
15. Нийгэм , нийгмийн бүлгийн олонхи гишүүдийн хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, хүлээлттэй үл нийцэх төлөв. \2 оноо\
- |                    |                        |             |               |
|--------------------|------------------------|-------------|---------------|
| a. Нийгмийн хяналт | b. нийгмийн хэм хэмжээ | c. Гажуудал | d. Конформист |
|--------------------|------------------------|-------------|---------------|
16. Манай орон гадаадын хэрэглэгчдэд бараагаа худалдаж орлого олохыг юу гэх вэ? \2 оноо\
- |                  |                     |                    |           |
|------------------|---------------------|--------------------|-----------|
| a. цэвэр экспорт | b. экспортын орлого | c. импортын орлого | d. гадаад |
| худалдаа         |                     |                    |           |
17. Инфляцийн үед хэн хожих вэ? \2 оноо\
- |                         |                                |                                 |                                 |
|-------------------------|--------------------------------|---------------------------------|---------------------------------|
| A. Төрийн албан хаагчид | b. Банкинд хадгаламжтай хүмүүс | c. Банкнаас зээл авсан хувь хүн | d. Өр зээлээ төлж байгаа хүмүүс |
|-------------------------|--------------------------------|---------------------------------|---------------------------------|
18.  $M > \frac{PQ}{T}$  үед эдийн засагт ямар нехцэл үүсэх вэ? \2 оноо\
- М-Гүйлгээнд байх мөнгөний хэмжээ
- PQ-Бүтээгдэхүүн, үйлчилгээний нийт үнийн дүн
- Т-Мөнгөний эргэлтийн хурд
- a. Эдийн засагт мөнгөний илүүдэл бий болж мөнгө үнэ цэнээ алдаж улмаар инфляци үүснэ.  
 b. Эдийн засагт мөнгөний хомсдол үүсэж нийт эрэлт буурна.  
 c. Гүйлгээнд байгаа мөнгөний тоо хэмжээ, үйлдвэрлэсэн бараа үйлчилгээний үнийн дүнтэй тэнцэж тогтворжино.

d. Гүйлгээнд байгаа мөнгөний тоо хэмжээнд өөрчлөлт гарахгүй.

19. Инфляци өсөх хандлагатай байсан ба иргэд дараах үйлдлүүдийг хийсэн гэвэл аль нь илүү

оновчтой шийдвэр вэ? (2 оноо)

- A. Орон сууцаа худалдсан      B. Мөнгөөрөө орон сууц худалдаж авсан  
C. Орон сууцаа машинаар сольсон      D. Мөнгөө банкинд хадгалуулсан  
E. Мөнгөө гэртээ хадгалсан

20. Навчаа хүссэн ажлаа хийхийн тулд гадаад хэл суралцахаар ажлаас завсардсан энэ ямар ажилгүйдэл вэ? (2 оноо)

- a. Бүтцийн      b. Мөчлөгийн      c. Шилжилтийн      d. Улирлын

21. Иргэдийн худалдан авалт муудаж олон үйлдвэрийн газар хаалгаа барьснаас Хуяг ажилгүй болсон нь ямар ажилгүйдэл вэ? (2 оноо)

- b. Бүтцийн      B. Мөчлөгийн      c. Шилжилтийн      d. Улирлын

22. "Ардчилал бол хамгийн муу засаглалын хэлбэр, гэхдээ хүн төрөлхтөн үүнээс илүүг олоогүй байна" гэж хэн хэлсэн бэ? (2 оноо)

- A. Ж.Локк      b. А.Линкольн      c. К. Поппер      d. У. Черчилль

23. Аливаа төрд 3-н төрлийн эрх мэдэл оршдог гээд хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэл хэмээн ангилсан байдаг эрдэмтнийг сонгоно уу? (2 оноо)

- A. Д.Инстон      b.Н.И.Б.Макисвелли      c.Ш.Монтесье      d.Ж.Локк

24. Засгийн газрын үйл ажиллагааны эрх зүйн баримт бичиг аль нь вэ? (2 оноо)

- a. тогтоол, захирамж      b. зарлиг      c. шийдвэр      d. уриалга

25. Ардчиллын бус үнэт зүйлийг нэрлэнэ үү?. (2 оноо)

- A. Хүний эрх      B. Шударга сонгууль      C.Эрх мэдлийн төвлөрөл      D. Нээлттэй байдал      E. Хуульд захирагдах ёс

26. Иргэдэд адил тэнцүү боломж олгодог ба энэ нь хэн нэгнийг илүү харж, эрх дарх олгохгүй гэсэн үг юм (2 оноо)

- A .Хууль дээдлэх зарчим      B. Шударга байх зарчим      C. Нээлттэй байх  
D. Аль нь ч биш

27. Монгол улс хэдийд нутаг дэвсгэрээ цөмийн зэвсэггүй бус болгож зарласан бэ? (2 оноо)

- a. 1990 он      b. 1992 он      c. 1995 он      d. 2003 он

28. ОУХ-нд оролцогч улс бус оролцогчдоос илүүцийг олно уу. (2 оноо)

- A. Тусгаар тогтносон улсууд      b. Далай лам      c. НҮБ      d. Coco cola

29. Тухайн улсыг бүрэн бус хэмээн хүлээн зөвшөөрсөн хэлбэр аль нь вэ? (2 оноо)

- A. де-факто      b. де-юре

30. Олон улсын харилцааны хүмүүнлэгийн салбарт хамарагдахгүй чиглэлийг дурьдсан бол аль нь вэ? (2 оноо)

- A. Эмэгтэйчүүд, хуухдийн эрхийг хамгаалах  
B. Химийн болон бактерологийн зэвсэг дэлгэрүүлэхгүй байх  
C. Ядуурал, гуйланчлал, өлсгөлөнг арилгах  
D. Хүний эрхийг хамгаалах  
E. Бүгд хамарагдана

Хоёрдугаар хэсэг 10 даалгавар 40 оноо

1. Ойлголтуудыг тайлбартай нь зөв тохируулан хүснэгтийн хоосон зайд тохирох үсгийг бичээрэй. (4 оноо)

Байр суурь	Үүрэг	Харилцан үйлдэл	Эрх
A.Тухайн байр сууриас үүдэн бий	b. Тухайн хүн юуг хийх нь	c. Хоёр ба түүнээс дээш тооны хүмүүс харилцан бие	d. Хувь хүний эдлэх эрх, боломж,

болж, заавал биелүүлэх ёстой, хэм хэмжээлэг шинжтэй зан үйлүүдийн цогц.	хүлээн зөвшөөрөгдеж байгааг хэлнэ.	биенийхээ үйлдэлд бэлгэ тэмдгийг ашиглах замаар хариу ёгч буй үйл явцыг хэлнэ.	гүйцэтгэх үүрэг, бусдын зүгээс хандах хандлагын цогц.

2. Монгол улсын иргэний үндсэн ба журамт үүргийг ангилан бичээрэй. \ 4 оноо\

Монгол улсын иргэний үүрэг	Үндсэн үүрэг	Журамт үүрэг
1.Хуулийг дээдлэн хүндэтгэх, биелүүлэх		
2. Хөдөлмөрлөх		
3. Байгаль орчноо хамгаалах		
4. Албан татвар төлөх		
5. Эрүүл мэндээ хамгаалах		
6. Цэргийн алба хаах		

3. Дараах ажил үйлчилгээнээс алийг нь ДНБ –д тооцох, үл тооцохыг тэмдгээр ялгаж тайлбарлаарай. \4 оноо\

№	Жишээ	ДНБ-д тооцогдох эсэх	
		Тийм	Үгүй
1	Тухайн жилд үйлдвэрлэсэн боловч борлогдож амжаагүй бүтээгдэхүүний үнэ		
2	Тухайн жилд үйлдвэрлэсэн талхны үнэ		
3	Эцсийн хэрэглээнд зориулагдаагүй барааны үнэ		
4	Тухайн орны нутаг дэвсгэр дээр гадаадын хөрөнгөөр баригдсан үйлдвэрийн газруудын үйлдвэрлэсэн барааны үнэ		
5	Сүүдрийн эдийн засагт үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүний үнэ		

4. зөв харгалзуулаарай \4 оноо\

1	Гомдол	A	Захиргааны байгууллагын буруугаас иргэн , хуулийн этгээдийн эрх нь зөрчигдөж , зөрчигдсөн эрхээ сэргээлгэхээр гаргасан хүсэлт
2	Өргөдөл	Б	Өөрт болон бусдад туогарч буй асуудлыг шийдвэрлүүлэх тухай захиргааны байгууллагад хандаж буй баримт
3	хүсэлт	В	Байгууллага, албан тушаалтнаас гаргасан шийдвэр
4	Захиргааны шийдвэр буюу акт	Г	Тодорхой ажиллагааг эхлүүлэх, эсвэл дуусгавар болгох тухай захиргааний байгууллагад гаргасан хүсэлт

5. Зөв харгалзуулна уу. \4 оноо\

1	Олон тулгуурт байх	A	Стратегийн зорилтыг хэрэгжүүлэхдээ шат дарааллыг эрхэмлэсэн, сонирхлыг тэнцвэржүүлэхэд чиглэнэ.
2	Прагматик байх	Б	МУ-ийн үндэсний эрх ашиг аюулгүй байдлыг сахин хамгаалах үүднээс аль болох олон улс оронтой хамтрас, гадаад харилцааг аль болох олон хэлбэрээр явуулахад оршино.
3	Тэнцвэртэй байх	B	Энэ зарчим нь гадаад харилцаа, хамтын ажиллагаандаа нөөц бололцоог аль болох бүрэн дайчлан зохион байгуулах

A. 1B2B3A      b. 1A2B3B      c. 1B2B3A      d. 1B2A3B

6. Зөв харгалзуулна уу. \4 оноо\

1	Гэр бүл	a	Эрүүл аж төрөх, эрүүл мэндийг хангах хамгаалах
2	Боловсрол	b	Нийгмийн нэгдэл нягтралыг хангах, дээд ариун зүйлд итгэх, сүсэглэх
3	Эдийн засаг	c	Амгалан тайван байдлыг хангах, нийтлэг асуудлыг шийдэх
4	Төр засаг	d	Хэрэгцээт бараа, үйлчилгээгээр хангах
5	Шашин	e	Шинэ мэдлэг бүтээх, мэдлэгийг хойч үедээ уламжлуулах
6	Эрүүл мэнд спорт	f	Нийгмийн гишүүнийг төрүүлэх, нийгэмшүүлэх

a. 1d 2e 3c 4a 5b 6f      b. 1f 2e 3d 4c 5b 6a      c. 1a 2b 3c 4d 5e 6f      d. 1e 2f 3d 4a  
5b 6c

#### 7. Соёлын үүргүүдийг зөв харгалзуулна уу. \4 оноо\

1	Бэлгэдлийн чиг үүрэг	A	Соёл нь нийтлэг итгэл үнэмшил, үнэлэмжийн тогтолцоог бүрдүүлэх замаар нийгмийг нэгтгэдэг
2	Үнэлэмж, хэм хэмжээний чиг үүрэг	B	Өмнөх үеийн бүтээсэн нийгэм- соёлын уламжлалыг өвлүүлэх нь нийгмийн оршихуйн үндэс юм
3	Нэгтгэн, . зохицуулах чиг үүрэг	C	Нийгэмд үйлчилж байdag хэм хэмжээг эзэмшилж хүмүүс амьдралын чиг баримжаагаа олж байdag
4	Үйл ажиллагааны чиг үүрэг	D	Соёлын үзэгдлүүд тэмдгэн хэлбэрээр оршдог. Тэмдгийн хамгийн түгээмэл хэлбэр нь хэл юм

A. 1B,2C,3a,4D      b. 1D, 2C,3a,4B      c. 1D, 2B,3a,4C

#### 8. Зөв харгалзуулна уу. \4 оноо\

- |                             |                                  |               |    |
|-----------------------------|----------------------------------|---------------|----|
| A. Захирамж                 | 1. Ерөнхийлөгч                   |               |    |
| B. Зарлиг                   | 2. Аймаг нийслэлийн засаг дарга  |               |    |
| C. Тогтоол                  | 3. УИХ, Засгийн газар, дээд шүүх |               |    |
| D. Шийдвэр                  | 4. Ерөнхий сайд                  |               |    |
| E. Тушаал                   | 5. Үндсэн хуулийн цэц            |               |    |
| A. A2B1C3D5E4<br>A2B1C3D4E5 | b. A3B1C2D5E4                    | c. A2B1C4D5E3 | d. |

#### 9. Дараах бодомжуудыг зөв харгалзуулна уу. \4 оноо\

1. тодорхой хэмжээний мөнгийг тогтоосон хугацааны дараа, зохих хүйтэйгээр эргүүлэн төлөхөө амлаж байгааг баталсан үнэт цаас	a. Бонд
2. ямар нэгэн компанийн өмчийн тодорхой хэсгийг эзэмшиж буйг гэрчилсэн баримт	v. Үнэт цаас
3. засгийн газар болон бусад эрх бүхий этгээдээс гаргасан бүх төрлийн хувьцаа болон бонд, түүнийг худалдах, худалдан авах эрхийн бичгүүд	c. Хувьцаа

A. 1B2C3A      b. 1C2A3B      c. 1A2C3B      d. 1A2B3C

#### 10. Дараах тодорхойлтуудыг нөхөж бичихээр өгөгдсөн тулгуур ойлголтуудаас сонгон гүйцээн бичээрэй. \2 оноо\

- ..... нь нийгмийг амьд биетэй төстэй хэмээн үзсэн бөгөөд нийгмийн институт нь нийгмийн болон бусад институтийн оршин тогтолын төлөө тодорхой үүрэг гүйцэтгэж байдаг.
- ..... нь хүмүүс бэлгэ тэмдгээр дүүрэн ертөнцөд амьдардаг бөгөөд хүн тодорхой зүйлд хандан үйлдэл хийхдээ тухайн зүйл нь юу болохыг өөрөө хэрхэн ойлгож, төсөөлж байгаадаа тулгуурладаг.
- ..... нь нийгэм бол нөөцийг хянаж, эзэмшиж буй нийгмийн томоохон бүлгүүдийн зөрчил бүхий байдаг, нийгмийн байр суурийн ялгаа нь өөрсдийн ашиг сонирхлоо хэрэгжүүлэхийн төлөө зөрчилдөхөд хүргэдэг.

Нөхөх тулгуур ойлголт: Марксизм, бэлгэ тэмдэг харилцан үйлдлийн онол, бүтэц чиг үүргийн онол